



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Дотоод аудитын албаны эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1,270,000.00 (нэг сая хоёр зуун далан мянган) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн дотоод аудитын алба (Н.Наранчимэг)-нд зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 270,000,00 (хоёр зуун далан) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 1 нэр төрлийн 1,000,000.00 (нэг сая) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 10,000.00 (арван мянган) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 3,000.00 (гурван мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Баянгол дүүргийн дотоод аудитын алба (Н.Наранчимэг)-нд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150590228

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны дугаар сарын 4-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Дотоод аудитын алба

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын н үнийн санал	НӨХГ-ийн үнийн санал	ЭБХХК-ын үнийн санал
1	Компьютер суурин DELL I3	4	Ш	1	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	10,000.0	10,000.0
Номын фонд													
1	Байгууллагын архивын үндсэн зааврын эмхтгэл		Ш	5	10,000.00	50,000.00	-	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
2	Монтомерийн аудит		Ш	1	150,000.00	150,000.00	-	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
3	Архив албан хэрэг хөтлөлтийн талаарх эмхтгэл		Ш	1	35,000.00	35,000.00	-	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
4	Архив албан хэрэг хөтлөлтийн систем, тусгай төрлийн баримттай ажиллах арга зүй.		Ш	1	15,000.00	15,000.00	-	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
5	Төрийн аудит, Арга зүй шинжилгээ шинэчлэлт		Ш	1	20,000.00	20,000.00	-	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						1,270,000.00	1,000,000.00	-	-	-	-	10,000.00	10,000.00
Үүнээс Худалдах хөрөнгө						1,230,000.00	1,000,000.00	-	-	-	-	-	-
Актлах хөрөнгө						270,000.00	-	-	-	-	-	-	-
Татан төвлөрүүлэх хөрөнгө						-	-	-	-	-	-	-	-
Худалдсанаас олох орлого						10,000.00	-	-	-	-	-	-	-
НӨХГ-т төвлөрүүлэх 30%						3,000.00	-	-	-	-	-	3,000.00	3,000.00